



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.3 дахь хэсэг, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дулаан зогсоолд ажилтнуудын суудлын автомашин тавих журмыг нэгдүгээр хавсралтаар, автомашин нэвтрүүлэх хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дулаан зогсоолд ажилтнуудын суудлын автомашин тавих журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Аж ахуй эрхэлсэн дэд захирал Б.Төрмөнхөд даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэсгийн дарга, Дотоод аудитор Б.Бямбасүрэнд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ

Амгалан дулааны станц ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2018 оны 10 сарын 31 өдрийн
А/100 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ДУЛААН ЗОГСООЛД АЖИЛТНУУДЫН СУУДЛЫН АВТОМАШИН ТАВИХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Энэхүү журмын зорилго нь Амгалан дулааны станц ХХК-ийн ажилтнуудын суудлын автомашиныг өвлийн улиралд дулаан зогсоолд тавихад техник ашиглалтын, галын аюулгүй байдлын шаардлага хангах, автомашин дулаан зогсоолд тавих үеийн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Амгалан дулааны станц ХХК-ийн дулаан зогсоолд тус компанийн ажилтнуудын суудлын автомашиныг байрлуулна.

Гурав. Дулаан зогсоолд тавигдах шаардлага

3.1 Дулаан зогсоол нь гал түймэр гарсан үед автомашиныг авран хамгаалах, нүүлгэн шилжүүлэх схемийг үзүүлсэн самбар, галын булан, гал унтраах анхан шатны багаж хэрэгслэлээр иж бүрэн тоноглогдсон байна. Зогсоолын талбайн 50 метр тутамд гал унтраагуурыг байрлуулна.

3.2 Автомашиныг зогсоолд тавихдаа тэдгээрийн овор хэмжээний нормативт зохицуулан орох гарах үйлдлийг чөлөөтэй гүйцэтгэх, эргэж тойрох, ухрах хөдөлгөөн хийх нөхцөл бололцоог бүрэн хангасан байна.

3.3 Зогсоолд хөдөлгөөний урсгалын чиглэл, хурдны хязгаарыг заасан тэмдэглэгээ, шугамын зурвас тавьж, гэрэлтүүлгээр сайн хангасан байна. Гэрэлтүүлэг нь ажлын байрны гэрэлтүүлгийн шаардлагыг бүрэн хангасан байна.

3.4 Дулаан зогсоолын дотор болон гадна талбайд тамхи татахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээ тавина.

3.5 Дулаан зогсоол нь техникийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний болон галын аюулгүй байдлыг хангах үүднээс камержуулсан байна.

Дөрөв. Суудлын автомашин эзэмшигч нарт тавих шаардлага

4.1 Суудлын автомашин эзэмшигч нь автотмашинаа зориулалтын байрлалд байрлуулна.

4.2 Зогсоолд автомашинаа тавих үед цахилгаан хэлхээг салгаж, тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдалд тавих шаардлагыг бүрэн хангасан байна.

4.3 Автошиныг зогсоолд байрлуулж тавихад дараах заалтуудыг хориглоно. Үүнд:

А. Хөдөлгүүрийг удаан хугацаагаар асааж кабинд суух /автошинаа асаалттай 5 минутаас хэтрэх/

Б. Засвар үйлчилгээ хийх

В. Автошинаа зураас гишгүүлэх, хазгай байрлуулах, орц, гарц хааж тавих

Г. Дулаан зогсоолын дотор болон гадна талбайд тамхи татах, согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэх, хулгай хийх, сэлгүүцэх

Д. Автошинаа зогсоолд удаан хугацаагаар орхих

Е. Автошин дотор тэсэрч дэлбэрэх аюултай бодис, үнэт зүйлс үлдээх.

4.4 Автошиныг зогсоол дотор хөдөлгөөнд оруулахад хөдөлгөөний болон тавилтын нормативт зай хэмжээг нарийн баримтлан, огцом эргэлт, хөдөлгөөн хийхгүй нямбай ажиллах, ухрах хөдөлгөөн хийхдээ шаардлагатай гэж үзвэл бусдын туслалцааг авна.

4.5 Автошин эзэмшигч нь харуул, хамгаалалтын ажилтны тавьсан шаардлагыг биелүүлнэ.

4.6 Ажилтан нь харуулын постоор нэвтрэхдээ ажлын үнэмлэх болон автошины нэвтрэх зөвшөөрлийн бичгийг харуулын ажилтанд шалгуулж орно.

4.7 Автошин бүр галын хортой байхаас гадна галын хор нь бүрэн цэнэгтэй, шаардлагатай тохиолдолд авч ашиглах бололцоотой байх.

Тав. Харуул, хамгаалалтын ажилтны эрх, үүрэг

5.1 Харуулын ажилтан нь нэвтрэн орох ажилтнуудын ажлын үнэмлэх, автошины нэвтрэх зөвшөөрлийн бичгийн хамт шалгаж нэвтрүүлнэ.

5.2 Тээврийн хэрэгслийн дотор болон ачааны хэсгийг шалгах ба шаардлагатай тохиолдолд нарийвчилсан үзлэг, шалгалтыг хийнэ.

5.3 Харуулын постоор зөвхөн Аж ахуй эрхэлсэн дэд захирлын олгосон нэвтрэх үнэмлэхтэй суудлын автошиныг нэвтрүүлнэ.

5.4 Харуулын постоор нэвтрэх тээврийн хэрэгсэл болон ажилтныг шалгах явцад илэрсэн зөрчлийн тухай байгууллагын удирдлагад цаг тухайд нь танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.5 Автошинд зорчин яваа ажилтнуудын ажлын үнэмлэхийг нь шалгаж байхгүй тохиолдолд нэвтрүүлэхгүй.

5.6 Харуулын постоор автошингүй явган ажилтнуудыг нэвтрүүлэхгүй.

5.7 Харуулын постоор согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, авч орохыг завдсан иргэн, ажилтныг объектод нэвтрүүлэхгүй.

Зургаа. Бусад

6.1 Автошины галын хор нь бүрэн цэнэгтэй, авч ашиглах бололцоотой эсэхийг тогтмол шалгаж байх, дулаан зогсоолын аюулгүйн ажиллагаа, галын аюулгүйн норматив шаардлагуудад тогтмол үзлэг шалгалтыг хяналтын хэсэг хийнэ.

6.2 Дулаан зогсоолын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Аж ахуй, хангамжийн албаны дарга, Авто хүнд машин механизмын хэсгийн инженер хариуцна.

6.3 Дулаан зогсоолын барилга байгууламжийн /гэрэлтүүлэг, камер, тэмдэг, тэмдэглэгээ, дулаацуулга, түүний шугам хоолой, хаалга, цонхны бүрэн бүтэн байдал/ гэх мэт/ тохижилтын ажлыг Барилга, сантехникийн инженер хариуцан ажиллана.

6.4 Дулаан зогсоолд тэмдэглэгээ хийсэн байх ба нэгж бүрт зогсоолыг хувиарлаж өгнө. Өөрийн нэгжийн хуваарьт талбайгаас өөр нэгжийн хуваарьт талбайд суудлын автомашинаа байрлуулахыг хориглоно.

6.5 Спорт заал, хурлын танхим, сургалтын танхим хариуцсан жижүүр нь дулаан зогсоолын өдөр тутмын цэвэрлэгээнд хяналт тавих бөгөөд нэгж нь өөрийн хуваарьт зогсоолоо цаг тухайд нь цэвэрлэх ба 7 хоног бүрийн баасан гаригийн өглөө буусан ээлжийн инженер их цэвэрлэгээг хариуцан хийлгэнэ.



Амгалан дулааны станц ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2018 оны 10 сарын 31 өдрийн
А/100 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

№

Овог нэр:

Албан тушаал:

Автомашинны улсын дугаар, сери:

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:

АЖ АХУЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ

Б.ТӨРМӨНХ

Дулаан зогсоолд суудлын автомашин тавих хүчинтэй хугацаа:

201.. оны 11 дүгээр сарын 01-нээс 201.. оны 04 дүгээр сарын 01 хүртэл хүчинтэй

Жич: Үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгохгүй.

